



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/387

Булган сум

Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалтууд, Засгийн газрын 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн "Алтаргана 2024" наадмын бэлтгэл ажлыг ханган "Нисдэг ор" ХХК-тай иж бүрэн тавилгатай 1 ширхэг 6 ханатай сийлбэртэй гэр нийлүүлэх 19,200,000 (арван есөн сая хоёр зуун мянга) төгрөгийн гэрээ байгуулан, хяналт тавьж, хүлээн авахыг Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т үүрэг болгосугай.

2. Иж бүрэн тавилгатай монгол гэрийг чанарын өндөр түвшинд нийлүүлж хүлээлгэн өгөхийг "Нисдэг ор" ХХК-ны захирал (У.Төгөлдөр)-д даалгасугай.

3. Санхүүжилтийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн "Алтаргана 2024" арга хэмжээний төлөвлөгдсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

4. Гэрээний дагуу нийлүүлэгдсэн ирж бүрэн тавилгатай монгол гэрийг байгууллагын дансанд бүртгэж, тайлагнахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний албаны дарга (Х.Энхбаатар), Ахлах нягтлан бодогч (Д.Баясгалан) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

